# БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 26 өдөр Дугаар А/471 Булган сум

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Алтаргана 2024” олон улсын XV их наадмын бэлтгэл ажлын хүрээнд Хөгжимт жүжгийн театрын гадна болон дотор засварын ажлын зардлыг хавсралтаар баталж, 7,174,000 (долоон сая нэг зуун далан дөрвөн мянга) төгрөгөөр хууль, дүрэм журмын дагуу гэрээ байгуулах эрхийг Хөгжимт жүжгийн театрын дарга (О.Ууганчимэг)-д олгосугай.

2.Гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д үүрэг болгосугай.

3.Дээрх хөрөнгийг орон нутгийн хөгжлийн сангийн “Алтаргана 2024” арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

4.Гэрээний биелэлтийн дагуу хүлээн авсан барааг бүртгэл хөтөлж, тайлагнахыг Хөгжимт жүжгийн театрын дарга (О.Ууганчимэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/3захирамж

6324010607

Аймгийн Засаг даргын 2024 оны
06 дугаар сарын 26-ны/ний өдрийн А/431 дугаар
захирамжийн хавсралт

“Алтаргана 2024” олон улсын XV их наадмын бэлтгэл ажлын хүрээнд
Хөгжимт жүжгийн театрын гадна болон дотор засварын зардлын тооцоо

| Д/д | Зардлын нэр | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Дотор 2 талын хана 2.440х6.50 | м | 40,000 | 1,248,000 |
| 2 | Рам прус 4м | ш | 7000 | 70,000 |
| 3 | Шрүп | хайрцаг | 12,000 | 12,000 |
| 4 | Гадна багана бөөрөнхий тойрог-1.10, өндөр-3,40 | м | 40,000 | 149,600 |
| 5 | Гадна хашаа урт-2.70, өндөр-1.35 | м | 40,000 | 1,749,600 |
| 6 | Улаан урт нарийн хивс | м | 110,000 | 880,000 |
| 7 | Тайзны фон хөшиг | ком | 3,065,000 | 3,065,000 |
| **Нийт үнэ** | | | | **7,174,000** |